

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/006/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Отгонбаяр
Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn

Аудитор: Э.Ундармаа
Утас: 325093 Цахим хаяг: undarmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт	15
5.2 Албан шаардлага	15
5.3 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДЭХ	Дулааны эрчим хүч
Мян.Гкал	мянган Гигакалори
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-03-13 № 611
танай _____-ны № _____-т

БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.АРИУН-ЭРДЭНЭ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур дулааны станц ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ийн өдрөөрх санхүүгийн байдал орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийт 12,214.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 12,998.7 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 106.4 хувьтай байна. Энэ нь 12 дугаар сард Улсын төсвөөс 550.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон, мөн борлуулалтын орлого 83.2 сая төгрөгөөр, үйл ажиллагааны бус орлого 200.9 сая төгрөгөөр тус тус давж биелсэнтэй холбоотой байна.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус компанийн талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул компанийн тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тайлант онд 12,998.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 15,054.9 сая төгрөгийн зардал гаргаж, 3,056.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан

1426050601

C:\Users\arangerin\Desktop\Бичиг хэргийн 2025\2025-03-13\Бичиг хэргийн 2025.docx

байна. Төлөвлөгөөгөөр 3,474.1 сая төгрөгөөр алдагдалтай ажиллахаар баталсныг 10.2 хувиар алдагдлын хэмжээг бууруулсан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Эрчим хүчний сайдын 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/306 дугаар тушаалаар баталсан "Техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө"-ний 12 үзүүлэлтээс 9 үзүүлэлтийг биелүүлж, 3 үзүүлэлт биелэх боломжгүй нөхцөл үүсэж, төлөвлөгөөний биелэлт 75.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,140,582,638.89	956,167,931.16
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,590,759.92	40,079,873.1
31100	Кассад байгаа бэлэн мөнгө	-	1,000.0
31110	Төгрөг	-	1,000.0
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	15,590,759.92	40,078,873.1
31210	Төгрөг	15,590,759.92	40,078,873.1
31213	Арилжааны банк дахь харилцах	15,590,759.92	40,078,873.1
33	АВЛАГА	594,996,611.01	398,368,200.55
33401	Дансны авлага /ТӨХК/	546,928,213.24	341,216,183.34
33500	Бусад авлага	48,068,397.77	57,152,017.21
33510	Байгууллагаас авах авлага	48,068,397.77	57,152,017.21
34	УРЬДЧИЛГАА	44,200,000.00	610,650.1
34600	Урьдчилж гарсан зардал	44,200,000.00	610,650.1
35	БАРАА МАТЕРИАЛ	485,795,267.96	517,109,207.5
35100	Түүхий эд материал	48,017,288.23	43,296,436.36
35110	Тусгай зориулалттай материал	48,017,288.23	43,296,436.36
35400	Хангамжийн материал	437,777,979.73	473,812,771.14
35410	Багаж хэрэгсэл	8,034,999.95	8,651,909.04
35420	Аж ахуйн материал	59,810,174.47	58,687,045.47
35430	Сэлбэг хэрэгсэл	247,337,032.09	253,790,472.89
35440	Түлш, шатах тослох материал	1,030,978.37	2,805,086.44
35450	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа	110,888,353.94	98,658,328.2
35470	Бусад бараа материал	10,676,440.91	51,219,929.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,517,003,293.16	12,695,869,858.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,517,003,293.16	12,695,869,858.72
39200	Биет хөрөнгө	11,307,503,320.84	11,486,369,886.4
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,207,202,494.4	9,571,065,979.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	(4,337,345,718.93)	(4,749,880,757.65)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	838,224,890.31	804,607,617.58
39204	Хуримтлагдсан элэгдэл	(486,244,527.03)	(503,354,816.62)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	12,978,670,842.98	13,714,974,231.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,047,944,560.12)	(7,480,349,826.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	117,078,620.73	79,408,554.55
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,139,040.57)	(29,671,666.14)
39214	Бусад үндсэн хөрөнгө	328,814,242.51	325,559,242.51
39215	Хуримтлагдсан элэгдэл	(245,813,923.44)	(245,988,672.36)
39300	Биет бус хөрөнгө	1,059,273,600.00	1,059,273,600.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,059,273,600.00	1,059,273,600.00
39400	Бусад хөрөнгө /ТӨХК/	150,226,372.32	150,226,372.32
39403	Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨХК/	150,226,372.32	150,226,372.32
39405	Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨХК/		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	13,657,585,932.05	13,652,037,789.88
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,890,230,891.52	6,328,026,689.82
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,831,746,770.58	6,328,026,689.82
41300	Өглөг	3,814,863,561.15	6,305,218,197.8

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	137,451,723.52	155,269,608.73
41360	Бусад өглөг	3,677,411,837.63	6,149,948,589.07
41363	Татварын өглөг /ТӨХК/	1,485,832,548.13	1,781,463,586.41
41364	НДШ-ийн өглөг /ТӨХК/	192,061,203.20	716,889,830.96
41366	Дансны өглөг /ТӨХК/	1,999,518,086.30	3,626,735,356.39
41400	Урьдчилж орсон орлого	16,883,209.43	22,808,492.02
41440	Бусад урьдчилж орсон орлого	16,883,209.43	22,808,492.02
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	58,484,120.94	122,310,437.19
42300	Хойшлогдсон татварын өр	58,484,120.94	122,310,437.19
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,767,355,040.53	7,201,700,662.87
51	Засгийн газрын хувь оролцоо	9,767,355,040.53	7,201,700,662.87
51101	Өмч /төрийн/ /ТӨХК/	14,265,749,636.31	18,893,130,963.31
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨХК/	4,875,866,327.00	804,780,460.0
51200	Хуримтлагдсан үр дүн	(13,336,025,643.18)	(16,457,975,480.84)
51210	Өмнөх үеийн үр дүн	(14,599,662,092.12)	(13,336,025,643.18)
51220	Тайлант үеийн үр дүн	1,277,729,681.60	(3,120,047,626.23)
51220	Залруулга	(14,093,232.66)	(1,902,211.43)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,961,764,720.40	3,961,764,720.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	13,657,585,932.05	13,652,037,789.88

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,094,234,017.10	(1,466,950,436.45)
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,094,234,017.10	(1,466,950,436.45)
120	Нийтлэг татварын бус орлого	3,094,234,017.10	(1,466,950,436.45)
120005	Түрээсийн орлого	5,314,680.00	6,073,920.0
120009	Бусад орлого	6,445,442,927.32	2,656,012,544.46
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨХК/	9,208,852,062.54	10,336,604,959.02
120011	Борлуулалтын өртөг /ТӨХК/	12,565,375,652.76	14,465,641,859.93
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,816,504,335.50	1,653,097,189.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,816,504,335.50	1,653,097,189.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,816,504,335.50	1,653,097,189.78
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,816,504,335.50	1,653,097,189.78
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨХК/	461,630,408.35	673,130,587.47
210812	Санхүүгийн зардал /ТӨХК/	15,844,681.11	18,684,308.26
210813	Бусад зардал /ТӨХК/	1,132,076,906.82	897,442,030.4
21081	Орлогын татварын зардал /ТӨХК/	206,952,321.22	63,840,263.65
210815	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(18.00)	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,277,729,681.60	3,120,047,626.23
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,277,729,681.60	3,120,047,626.23

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2024 оны 1-р сарын 01-ний үлдэгдэл	14,270,749,636.31	3,674,112,627.32	(14,599,662,092.07)	3,345,200,171.56
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,270,749,636.31	3,961,764,720.40	(14,613,755,324.73)	3,618,759,031.98
3	Өмчид гарсан өөрчлөлт	4,870,866,327.0	-	-	4,870,866,327.0
4	Тайлант үеийн үр дүн	-	-	1,277,729,681.65	1,277,729,681.65
5	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	19,141,615,963.31	3,961,764,720.40	(13,336,025,643.18)	9,767,355,040.53
6	2025 оны 1-р сарын 1-ны үлдэгдэл	19,141,615,963.31	3,961,764,720.40	(13,336,025,643.18)	9,767,355,040.53
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,902,211.43)	(1,902,211.43)
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	19,141,615,963.31	3,961,764,720.40	(13,337,927,854.61)	9,765,452,829.1
9	Өмчид гарсан өөрчлөлт	556,295,460.00	-	-	556,295,460.00
10	Тайлант үеийн үр дүн	-	-	(3,120,047,626.23)	(3,120,047,626.23)
11	2025 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	19,697,911,423.31	3,961,764,720.40	(16,457,975,480.84)	7,201,700,662.87

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	13,360,033,826.41	9,928,033,836.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,473,519,096.41	7,378,033,836.04
120	Нийтлэг татварын бус орлого	6,473,519,096.41	7,378,033,836.04
120009	Бусад орлого	92,546,626.28	49,298,257.08
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨХК/	6,380,972,470.13	7,328,735,578.96
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,886,514,730.00	2,550,000,000.0
1330	Төсвийн захирагчдаас	6,886,514,730.00	2,550,000,000.0
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	6,886,514,730.00	2,550,000,000.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,607,268,736.18	9,473,095,453.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,607,268,736.18	9,473,095,453.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,607,268,736.18	9,473,095,453.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,963,553,998.32	4,278,009,016.93
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨХК/	3,963,553,998.32	4,278,009,016.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,153,172,659.75	858,545,334.40
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨХК/	1,153,172,659.75	858,545,334.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,235,704,068.20	84,808,000.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨХК/	2,235,704,068.20	84,808,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,437,823,759.60	1,255,595,289.68
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨХК/	2,433,053,165.85	383,008,755.47
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨХК/	1,004,770,593.75	872,586,534.21

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,817,014,250.31	2,209,137,812.27
210815	Хүүгийн төлбөр төлсөн /ТӨХК/		
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨХК/	958,691,216.50	794,045,676.91
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨХК/	858,323,033.81	1,415,092,135.36
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	752,765,090.23	454,938,382.76
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		3,000,000.00
	Мөнгөн орлогын дүн		3,000,000.00
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		3,000,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	792,814,549.15	433,449,269.58
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	792,814,549.15	433,449,269.58
2200	Дотоод эх үүсвэрээр	792,814,549.15	433,449,269.58
223001	Бусад хөрөнгө	792,814,549.15	433,449,269.58
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(792,814,549.15)	(430,449,269.58)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(40,049,458.92)	24,489,113.18
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	55,640,218.84	15,590,759.92
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,590,759.92	40,079,873.10

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /сая төгрөгөөр/

№	Техник, эдийн засгийн үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл-12 сар/өссөн дүнгээр/	2025 оны гүйцэтгэл-12 сар/өссөн дүнгээр/		Өөрчлөлт			
					төлөвлөгөө	гүйцэтгэл	өмнөх оноос		төлөвлөгөөнөөс	
							дүн 4=3-1	хувь 5=4/1	дүн 6=3-2	хувь 7=6/2
1	Боловсруулах ДЭХ		мян.Гкал	174.99	175.67	178.14	3.16	2%	2.5	1.4%
	Дотоод хэрэгцээний дулаан эрчим хүчний зарцуулалт	хувиар	хувь	2%	2%	2%	0%	9%	0.0	-2.1%
		бистгээр	мян.Гкал	3.31	3.70	3.67	0.36	11%	-0.03	-0.7%
	Түгээх ДЭХ		мян.Гкал	171.67	171.97	174.47	2.80	2%	2.5	1.5%
2	Нийт орлого		сая.төг	15,659.6	12,214.6	12,998.7	(2,660.9)	-17%	784.1	6.4%
	Үүнээс:	ДЭХ Борлуулалтын орлого	сая.төг	9,208.9	10,253.5	10,336.6	1,127.8	12%	83.2	0.8%
		Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	190.3	143.0	343.9	153.6	81%	200.9	140.6%
		Улсын төсвийн санхүүжилт	сая.төг	6,260.5	1,818.2	2,318.2	(3,942.3)	-63%	500.0	27.5%
3	Нийт зардал		сая.төг	14,174.9	15,688.7	16,054.9	1,880.0	13%	366.2	2.3%
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	сая.төг	13,660.3	15,605.9	15,961.8	2,301.5	17%	355.9	2.3%
		Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	514.7	82.8	93.1	(421.6)	-82%	10.3	12.4%
4	Татварын өмнөх ашиг/алдагдал		сая.төг	1,484.7	(3,474.1)	(3,056.2)	(4,540.9)	-306%	417.9	-12.0%
5	Татварын дараах ашиг/алдагдал		сая.төг	1,277.7	(3,474.1)	(3,120.0)	(4,397.8)	-344%	354.1	-10.2%
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал		төг	1.48	1.52	1.54	0.06	4%	0.02	1.3%
7	Нийт авлага		сая.төг	595.0	982.9	398.4	(196.6)	-33%	-584.5	-59.5%
	Үүнээс:	Борлуулалтын авлага	сая.төг	546.9	982.9	341.2	(205.7)	-38%	-641.7	-65.3%
		Бусад	сая.төг	48.1	-	57.2	9.1	19%	57.2	0.0%
8	Нийт өглөг		сая.төг	3,890.2	5,649.8	6,450.3	2,560.1	66%	800.5	14.2%
	Үүнээс:	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	58.5		122.3	63.8	109%	122.3	0.0%
		Богино хугацаат өр төлбөр	сая.төг	3,831.7	5,649.8	6,328.0	2,496.3	65%	678.2	12.0%
9	Нийт ажиллагсдын тоо		тоо	140.0	142.0	141.0	1.0	1%	-1.0	-0.7%
10	Нийт цалингийн сан		сая.төг	4,642.8	5,345.7	5,297.3	654.5	14%	-48.4	-0.9%
11	Жиншмэл түлшний хувийн зарцуулалт		кг/Гкал	199.0	191.3	185.9	(13.1)	-7%	-5.4	-2.8%
12	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		сая.төг	1,015.6	1,324.7	1,193.9	178.2	18%	-130.8	-9.9%
	Үүнээс:	Их засвар	сая.төг	254.9	449.7	439.3	184.5	72%	-10.4	-2.3%
		ТЗБАХ	сая.төг	192.9	30.0	29.6	(163.3)	-85%	-0.4	-1.3%
		Хөрөнгө оруулалт	сая.төг	567.9	845.0	724.9	157.1	28%	-120.0	-14.2%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 ТӨХК, түүний үйл ажиллагаа

Компанийн дүрэмд тус компанийн үйл ажиллагааны чиглэлийг “Дулааны эрчим хүчээр зохицуулалттай хангах, дулаан үйлдвэрлэх, дулаан түгээн борлуулах” гэж тодорхойлжээ.

Багануур дулааны станц ТӨХК нь 1980 онд 25 тонн ханасан уур үйлдвэрлэх хүчин чадалтайгаар, Багануурын нүүрсний уурхайг дулааны эрчим хүчээр хангах зорилготойгоор байгуулагдсан байна. Компани нь 1983 онд усан халаалтын 6 зуух, 1989 онд 2 зуух, уур үйлдвэрлэх 1 зуухыг нэмж ашиглалтад оруулснаар жилд 300 мян.Гкал дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай болж өргөжсөн байна.

Багануурын дулааны станц ТӨХК нь зорилгоо “Хэрэглэгчийг эрхэмлэн дээдэлж, дэвшилтэт технологид тулгуурлан дулааны эрчим хүчээр найдвартай хангаж, эдийн засгийн үр ашигтай ажиллахад оршино” гэж тодорхойлжээ.

Өмчийн 34.0 хувийг Эрчист монгол ТӨХХК, 66.0 хувийг Эрчим хүчний яам эзэмшиж байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Тус компани нь үйл ажиллагаандаа дараах хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд:

- Эрчим хүчний тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Татварын багц хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон албаны нууцын тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хууль;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт гарчээ. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын 4 сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн бүтэц, зохион байгуулалт, өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт хийх дотоод аудитортой боловч 2025 онд бүрэн орон тоогоор ажиллаагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт бүрэн тохирсон гэж үнэлж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/сая төгрөгөөр/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	15.6	40.1	24.5
Авлага	595.0	398.3	(196.7)
Урьдчилж гарсан зардал	44.2	0.6	(43.6)
Бараа материал	485.8	517.1	31.3
Үндсэн хөрөнгө	12,517.0	12,695.9	178.9
Нийт хөрөнгө	13,657.6	13,652.0	(5.6)
Өр төлбөр	3,814.9	6,328.0	2,513.1
Урьдчилж орсон орлого	16.9	22.8	5.9
Хойшлогдсон татварын өр төлбөр	58.5	122.3	63.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	23,103.4	23,659.7	556.3
Хуримтлагдсан ашиг	(13,336.0)	(16,458.0)	(3,122.0)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	13,657.6	13,652.0	(5.6)

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, урьдчилж орсон орлого, хойшлогдсон татварын өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснууд байна.Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 40.1 сая төгрөг болж 24.5 сая төгрөгөөр өссөн нь арилжааны 4 банканд нийт 14,263.9 сая төгрөгийн борлуулалтын орлого орж, үйл ажиллагааны зардалд 14,303.9 сая төгрөг зарцуулсантай;
- Авлага дансны үлдэгдэл 398.3 сая төгрөг болж 196.7 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдаад байсан Эрүүл мэндийн төвийн авлага барагдаж дансанд төвлөрсөнтэй;
- Бараа материалын данс нь өөрийн хөрөнгөөр худалдан авсан 4,333.6 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 4,301.0 сая төгрөгөөр буурсантай;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 12,695.9 сая төгрөг болж 178.9 сая төгрөгөөр өссөн нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 422 дугаар тогтоолоор Дүүргийн хөрөнгө оруулалтаар авсан 27 нэр төрлийн 556.3 сая төгрөг, өөрийн хөрөнгөөр худалдан авсан 314.4 сая төгрөг, нийт 870.7 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнтэй;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 6,328.0 сая төгрөг болж өмнөх оноос 2,513.1 сая төгрөгөөр өссөн нь эх үүсвэрийн дутагдлаас;
- Урьдчилж орсон орлого данс 22.8 сая төгрөгөөр өссөн нь айл өрх, ААН-ийн илүү төлөлтөөр;
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 23,659.7 сая төгрөг болж 556.3 сая төгрөгөөр өссөн нь эздийн өмчийн бусад хэсгийн өөрчлөлттэй тус тус холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн тайлант оны техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө /тодотгосон/-г Эрчим хүчний сайдын 2025 оны А/306 дугаар тушаалаар баталсан.

Тайлант оны орлогыг 12,214.6 сая төгрөг, зардлыг 15,688.7 сая төгрөг, 3,474.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталж, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажилд нийт 1,324.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Тайлант оны гүйцэтгэлээр 12,998.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 15,054.9 сая төгрөгийн зардал гаргаж, 3,056.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 12,998.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 784.1 сая төгрөгөөр буюу 6.4 хувиар давуулан биелүүлсэн үзүүлэлттэй байна. Үүнд:

- ДЭХ-ний борлуулалтын орлогын төлөвлөгөөгөөр нийт 10,253.5 сая төгрөг батлагдсанаас Багануур дүүргийн хэрэглэгчдэд 10,336.6 сая төгрөгийн ДЭХ-ийг борлуулж, биелэлт 83.2 сая төгрөгөөр буюу 0.8 хувиар давуулан биелүүлсэн нь гадна агаар температур өмнөх онуудтай харьцуулахад хүйтэн байсан тул аж ахуйн нэгж, байгууллагын ДЭХ-ний орлого нэмэгдэх шалтгаан болсон байна;
- Үйл ажиллагааны бус орлогыг нийт 143.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 343.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 200.9 сая төгрөгөөр буюу 40.6 хувиар давуулан биелүүлсэн байна;
- Улсын төсвийн татаас санхүүжилтийн орлогыг нийт 1,818.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,318.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 500.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг олгосонтой холбоотой 27.5 хувиар давж биелсэн байна.

Нийт зардлын төлөвлөгөөг 15,688.7 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 16,054.9 сая төгрөгийн зардал гаргаж, 366.2 сая төгрөгөөр буюу 2.3 хувиар хэтэрсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөг 15,605.9 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 15,961.8 сая төгрөгийн зардал гаргаж, төлөвлөгөөнөөс 355.9 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Энэ нь тухайн онд цахилгаан эрчим хүчний худалдан авах үнэ тарифыг 50 хувиар хөнгөлөхөөр төлөвлөгөөнд тусгагдсан боловч хэрэгжээгүйтэй холбоотой байна;
- Үйл ажиллагааны бус зардлын төлөвлөгөөг 82.8 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 93.1 сая төгрөгийн зардал гаргаж, төлөвлөгөөнөөс 10.3 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайлангаар газрын бүртгэл, санхүүгийн тайланд тусгасан газрын талбайн хэмжээний зөрүүг арилгах, тооллогын үр дүнг санхүүгийн тайлан, данс бүртгэлд үнэн зөв тусгах, гэрээний нөхцөл, гүйцэтгэлд үндэслэн зардлыг зөв хугацаанд хүлээн зөвшөөрөх, худалдан авсан бараа материалыг холбогдох нягтлан бодох бүртгэлийн дансаар дамжуулж, зөв ангилалд тусгах, төрийн өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулахтай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын Санхүүгийн аудитын албаны аудитор Э.Ундармаа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Отгонбаяр, санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр, дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг 2026 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 1/52 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 14,381.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 143.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор тус байгууллага нь хороодын байрны ашиглалтын зардлыг бууруулахын тулд халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир усны тоолуурыг шинэчлэн суурилуулах арга хэмжээг авч ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 24.6 сая төгрөгийн зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

Бараа материалын худалдан авалтыг бодит хэрэгцээнд тулгуурлан төлөвлөж гүйцэтгээгүй, 24.6 сая төгрөгийн илүүдэл нөөц үүсгэсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д *"нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх"* гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын *"нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын худалдан авалтыг бодит хэрэгцээнд тулгуурлан төлөвлөж гүйцэтгээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *"Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайлант онд ерөнхий гэрээгээр цахим дэлгүүрт байршуулсан оффисын тоног төхөөрөмж болон ширээ, сандал, бичиг хэргийн хэрэгсэл, цэвэрлэгээний материалыг өөрийн байгууллага дээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 78.6 сая төгрөгөөр худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т *"Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө"*, 4 дүгээр зүйлийн 4.1.8-д *"ерөнхий гэрээний арга гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг"*; 9 дүгээр зүйлийн 9.1-т *"Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ."* 38 дугаар зүйлийн 38.1-т *"Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна."* гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын *"нийцсэн бөгөөд зохистой байх"*, *"эрх ба үүрэг"* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны холбогдох журмыг мөрдөж ажиллаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Байгууллагын дотоод журамд сарын үйл ажиллагааны үр дүнгийн урамшуулал олгох нөхцөл, шалгуур үзүүлэлтийг тодорхой заагаагүй байна. Тухайлбал, сахилгын шийтгэл авсан албан хаагчид урамшуулал олгох эсэхийг холбогдох хууль тогтоомжтой уялдуулан судлаагүй, зохицуулалт байхгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6-д "хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлэх"; гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сахилгын шийтгэл авсан ажилтанд урамшуулал олгох эсэхийг Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжтой уялдуулан нарийвчлан тогтоох;

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Шалгагдагч компанийн 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 814.1 сая төгрөгийн 10 алдаа, зөрчил илрүүлж, зөвлөмж өгснөөс 4 зөрчил давтан гарсныг аудитын илрүүлэлтэд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 114.5 сая төгрөгийн зөрчлийг зогсоож, дахин давтан гаргахгүй ажиллах 7 албан шаардлага, 5.2 сая төгрөгийн 2 зөвлөмж өгснөөс авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан зөрчлүүд давтан гарсан байна.

Хүснэгт 2. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	7	114.5	6	68.9	85.7
Зөвлөмж	2	5.2	1	0	50.0
Нийт дүн	9	119.7	7	119.7	77.8

/сая төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Багануур дулааны станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдаа илрээгүй, аудитын явцад залруулга хийгээгүй болно.

Аудитаар 157.8 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 3.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 150.0 сая төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 4.2 сая төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 157.8 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Сарын үйл ажиллагааны үр дүнгийн урамшуулал олгохдоо сахилгын шийтгэл авсан ажилтнуудад 3.6 сая төгрөгийн урамшуулал олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д *"Төрийн өөрийн өмчийг зориулалт бусаар захиран зарцуулах, нийгмийн шинжтэй төсөл, арга хэмжээнд зарцуулах, хандив, тусламж, түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглох бөгөөд энэхүү хориглолтыг зөрчсөн эрх бүхий этгээдийг албан тушаалаас чөлөөлж, учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ."*, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д *"Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно."* гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын *"нийцсэн бөгөөд зохистой байх"*, *"эрх ба үүрэг"* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэл авсан ажилтнуудад олгосон урамшуулал 3.6 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Нийт 10.7 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;"* 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын *"нийцсэн бөгөөд зохистой байх"*, *"эрх ба үүрэг"* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Гурван автомашины спидометр хэмжигч төхөөрөмж эвдэрснээс шалтгаалж, жолоочийн тооцооны хуудасны явсан км-ийн зарцуулалтыг батлагдсан чиглэл, маршрут /км тооцсон/-ыг үндэслэн 70.9 сая төгрөгийн шатахууныг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т *"хүчин*

¹Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;", 13 дугаар зүйлийн 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно."* гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын *"нийцсэн бөгөөд зохистой байх"* болон *"эрх ба үүрэг"* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Автомашины тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаагүй, спидометрийн заалтыг үндэслэн шатахууны зарцуулалтыг тооцоогүй зөрчлийг зогсоож, дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3. Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 40.4 сая төгрөгийн гүйлгээг хийж, данс бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т *"хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"*, 13 дугаар зүйлийн 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын *"нийцсэн бөгөөд зохистой байх"* болон *"эрх ба үүрэг"* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл хангагдсан баримтаар гүйлгээ хийж хэвшээгүй зөрчлийг зогсоож, дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4. Үйл ажиллагааны чиглэл өөр аж ахуйн нэгжээр ажил гүйцэтгүүлж, төлбөр 28.0 сая төгрөгийг төлсөн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т *"Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална"*, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 4.5-т *"Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагааг ...зохих ёсоор хэрэгжүүлээгүй"* гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын *"нийцсэн бөгөөд зохистой байх"*, *"эрх ба үүрэг"* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл, тусгай зөвшөөрөл, чадавхыг харгалзан сонгоогүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Egazar.mn мэдээллийн сайтад нийт 65,619 м² талбайтай 13 газар бүртгэлтэй байхад санхүүгийн тайланд 65,669 м² талбайтай 13 газар бүртгэж, 50 м² талбай бүхий 0.8 сая төгрөгийн хөрөнгийг зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т *"үнэн зөв байх"*, 20 дугаар зүйлийн 20.2.3-т *"холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн

тайлагналын “үнэлгээ”, “орших байх”, “үнэн зөв байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын бүртгэл, санхүүгийн тайланд тусгасан газрын талбайн хэмжээний зөрүүг арилгах;

Илрүүлэлт-2: Эд хөрөнгийн тооллогын үр дүнгийн тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах,” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “үнэлгээ” болон “иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тооллогын үр дүнг санхүүгийн тайлан, данс бүртгэлд үнэн зөв тусгах, төрийн өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Урьдчилж гарсан 1.4 сая төгрөгийн зардлыг тайлант үеийн зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө.”, 8 дугаар зүйлийн 8.1-т “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах ...”, гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “үнэлгээ” болон “тохиолдсон байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээний нөхцөл, гүйцэтгэлд үндэслэн зардлыг зөв хугацаанд хүлээн зөвшөөрөх;

Илрүүлэлт-2: Бараа материал (өргөмжлөл, видео контент)-ыг шууд зардлаар 2.0 сая төгрөгийг тайлагнасан, хөрөнгийн дансанд бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”, Зар сурталчилгааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгч зар сурталчилгаатай холбоотой баримт болон тэдгээрийн хуулбарыг тухайн зар сурталчилгааг сүүлчийн удаа түгээснээс хойш 6 сараас доошгүй хугацаагаар хадгална.” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авсан бараа материалыг холбогдох нягтлан бодох бүртгэлийн дансаар дамжуулж, зөв ангилалд тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												/сая төгрөгөөр/	
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Сахилгын шийтгэл авсан ажилтнуудад урамшуулал олгосон	1	3.6	1	3.6									
Авлага, өр төлбөрийн үлдэгдэлд тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй.	1	10.7			1	10.7							
Гурван автомашины спидометр хэмжигч эвдэрснээс шалтгаалан шатахууныг тогтоосон маршрутаар олгосон.	1	70.9			1	70.9							
Анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан.	1	40.4			1	40.4							
Үйл ажиллагааны чиглэл өөр аж ахуйн нэгжээр ажил гүйцэтгүүлж, төлбөр төлсөн	1	28.0			1	28.0							
Эд хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй	1	-					1	-					
Бүртгэлтэй газрыг санхүүгийн тайланд зөрүүтэй тайлагнасан.	1	0.8					1	0.8					
Урьдчилж гарсан зардлыг тайлант үеийн зардалд бүртгэсэн.	1	1.4					1	1.4					
Бараа материалыг шууд зардлаар тайлагнасан, хөрөнгийн дансанд бүртгээгүй.	1	2					1	2					
Дүн	9	157.8	1	3.6	4	150.0	4	4.2	-	-	-	-	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цахим дэлгүүрт байршуулсан хөрөнгө худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй.	1	78.6			1	78.6		
Бараа материалын худалдан авалтыг бодит хэрэгцээнд тулгуурлан төлөвлөж гүйцэтгээгүй, илүүдэл нөөц үүсгэсэн.	1	24.6			1	24.6		
Байгууллагын дотоод журамд сарын үйл ажиллагааны үр дүнгийн урамшуулал олгох нөхцөл, шалгуур үзүүлэлтийг тодорхой заагаагүй.	1	-					1	-
Дүн	3	103.2	-	-	2	103.2	-	-



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 дугаар сарын 13

№ 108/А0270/192

Улаанбаатар хот

НТАГ-2026/006/НА-СТА-ТӨУГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур дулааны станц Төрийн өмчит хувьцаат компаний 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сарын үйл ажиллагааны үр дүнгийн урамшуулал олгохдоо сахилгын шийтгэл авсан ажилтнуудад 3,609,934.00 (гурван сая зургаан зуун есөн мянга есөн зуун гучин дөрвөн) төгрөгийн урамшуулал олгосон.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д "Төрийн өөрийн өмчийг зориулалт бусаар захиран зарцуулах, нийгмийн шинжтэй төсөл, арга хэмжээнд зарцуулах, хандив, тусламж, түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглох бөгөөд энэхүү хориглолтыг зөрчсөн эрх бүхий этгээдийг албан тушаалаас чөлөөлж, учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ", Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрөөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Багануур дулааны станц Төрийн өмчит хувьцаат компаний сахилгын шийтгэл авсан ажилтнуудад урамшуулал болгон олгосон 3,609,934.00 (гурван сая гурваан зуун есөн мянга есөн зуун гучин дөрвөн) төгрөгийг Багануур дулааны станц Төрийн өмчит хувьцаат компаний гүйцэтгэх захирал Б.Ариун-Эрдэнэ, ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал нараар төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банк дахь НТАГ. Хүү торгуулийн орлого, MN 44 0090 100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 28-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Багануур дулааны станц Төрийн өмчит хувьцаат компаний гүйцэтгэх захирал Б.Ариун-Эрдэнэ, ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Д.ОТГОНБАЯР
Э.УНДАРМАА

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110213



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 202/А0290182

Улаанбаатар хот

НТАГ-2026/006/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур дулааны станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 40,363,700.00 (дөчин сая гурван зуун жаран гурван мянга долоон зуу) төгрөгийн гүйлгээг хийж, данс бүртгэлд тусгасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй," заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэл хангагдсан баримтаар гүйлгээ хийж хэвшээгүй зөрчлийг зогсоож, дахин давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ариун-Эрдэнэ, ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Д.ОТГОНБАЯР
Э.УНДАРМАА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090565



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 208/ А0870 132

Улаанбаатар хот

НТАГ/- 2026/006/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур дулааны станц Төрийн өмчит хувьцаат компаний 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Спидометр хэмжигч төхөөрөмж эвдэрснээс шалтгаалж, гурван автомашины жолоочийн тооцооны хуудасны явсан км-ийн зарцуулалтыг батлагдсан чиглэл, маршрут /км тооцсон/-ыг үндэслэн 70,906,538.00 (далан сая есөн зуун зургаан мянга таван зуун гучин найм) төгрөгийн шатахууныг олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориолоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Автомашины тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаагүй, спидометрийн заалтыг үндэслэн шатахууны зарцуулалтыг тооцоогүй зөрчлийг зогсоож, дахин давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ариун-Эрдэнэ, ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Д.ОТГОНБАЯР
Э.УНДАРМАА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090563



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 299/А0290182

Улаанбаатар хот

НТАГ-2026/006/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур дулааны станц Төрийн өмчит хувьцаат компаний 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өр төлбөрийн 10,745,334.00 (арван сая долоон зуун дөчин таван мянга гурван зуун гучин дөрөв) төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ариун-Эрдэнэ, ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Д.ОТГОНБАЯР
Э.УНДАРМАА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090561



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 300/А0230182

Улаанбаатар хот

НТАГ-2026/006/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур дулааны станц Төрийн өмчит хувьцаат компаний 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын гэрчилгээнд тусгагдсан үйл ажиллагааны чиглэлд тусгагдаагүй бараа, ажил үйлчилгээг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, 27,980,000.00 (хорин болоон сая есөн зуун наян мянга) төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 4.5-д "Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагааг ... зохих ёсоор хэрэгжүүлээгүй" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл, тусгай зөвшөөрөл, чадавхыг харгалзан сонголт хийгээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ариун-Эрдэнэ, ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Д.ОТГОНБАЯР
Э.УНДАРМАА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090559



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 301/Ав 090182

Улаанбаатар хот

НТМ - 2026 / 006 / НА - СИМ - 7048

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур дулааны станц Төрийн өмчит хувьцаат компаний 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд ерөнхий гэрээгээр цахим дэлгүүрт байршуулсан оффисын тоног төхөөрөмж болон ширээ, сандал, бичиг хэргийн хэрэгсэл, цэвэрлэгээний материалыг өөрийн байгууллага дээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 78,585,721.00 (далан найман сая таван зуун наян таван мянга долоон зуун хорин нэг) төгрөгөөр худалдан авсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Улс, орон нутгийн төсөө болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "ерөнхий гэрээний арга гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг", 9 дүгээр зүйлийн 9.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ" 38 дугаар зүйлийн 38.1-д "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол;" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны холбогдох журмыг мөрдөж ажиллаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар


1426090557

2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ариун-Эрдэнэ, ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ
Д.ОТГОНБАЯР
Э.УНДАРМАА



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 502/А0230/82

Улаанбаатар хот

11001 - 2026/006/НА - 001 - 004/1

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур дулааны станц Төрийн өмчит хувьцаат компаний 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын худалдан авалтыг бодит хэрэгцээнд тулгуурлан төлөвлөж гүйцэтгээгүй, 24,569,688.00 (хорин дөрвөн сая таван зуун жаран есөн мянга зургаан зуун наян найм) төгрөгийн илүүдэл нөөц үүсгэсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-д "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Бараа материалын худалдан авалтыг бодит хэрэгцээнд тулгуурлан төлөвлөж гүйцэтгээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ариун-Эрдэнэ, ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Д.ОТГОНБАЯР
Э.УНДАРМАА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090555